



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/93

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дох заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2024 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөгжимт жүжгийн театрын эзэмшлийн дулааны шугам 4 удаа цоорч их хэмжээний усны алдагдал гарч үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан тус шугамыг засварлах ажлын гүйцэтгэгчээр дулаан, ус хангамж нийтийн аж ахуйн "Булган Мээж" ОНӨХХК-тай гэрээ байгуулахыг Хөгжимт жүжгийн театрын дарга (О.Ууганчимэг)-д үүрэг болгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох стандарт, журам, зааврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Булган Мээж" ОНӨХХК-ний захирал (Г.Ганбаатар)-д даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилт 67,739,115 (жаран долоон сая долоон зуун гучин есөн мянга нэг зуун таван) төгрөгийг төсвийн тодотголд тусгаж, орон нутгийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

